

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

(2022 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл
1.	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/561 дүгээр захирамж	Энэхүү хөтөлбөрийн зорилго нь төрийн албан хаагчийг сургах, хөгжүүлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажиллах орчин, нөхцлийг сайжруулах, ажлын идэвх санаачлага, гүйцэтгэл үр дүн, сахилга, хариуцлага, ёс зүйг харгалзан үнэлж, дүгнэн тэднийг шагнаж урамшуулах, амьдралд нь бодитой дэмжлэг үзүүлж, нийгмийн баталгааг хангахад оршино.
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улс, орон нутгийн төсөв, байгууллагын төсөв, бусад эх үүсвэр
3.	Хэрэгжүүлэгч байгууллага Хугацаа: 2021-2028 он	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Аймгийн Засаг даргын Тамгын газар Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар
4.	Хөтөлбөрийн зорилтууд	<p style="text-align: center;">1.Төрийн албан хаагчийн сургалт</p> Зорилт 1.1 Төрийн албан тушаалд тавих тусгай шаардлагын дагуу мэргэшүүлэх багц сургалтад хамруулах; Зорилт 1.2 Ажлын байран дахь сургалтыг тасралтгүй хөгжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх; Зорилт 1.3 Гадаад дотоодын их дээд сургууль, сургалтын байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд төрийн албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, дадлагажуулах сургалтад хамруулах; Зорилт 1.4 Төрийн албан хаагчийн зөөлөн ур чадварыг хөгжүүлэх; <p style="text-align: center;">2. Ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа</p> Зорилт 2.1 Ажлын байрны ажиллах орчин, нөхцлийг сайжруулах; Зорилт 2.2 Ажиллах эрч хүч, урам зоригийг нэмэгдүүлэх; Зорилт 2.3 Нийгмийн баталгаа, амьдрах орчин, нөхцлийг сайжруулах; Зорилт 2.4 Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх.

5	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	Төсвийн эх үүсвэрүүд: Байгууллагын төсөв, БОХНСАХэмжээний зардал, дотоод хуримтлал, тэтгэмж урамшууллын зардал		
		Үүнд:	Төсөв (2022 он)	Гүйцэтгэл (2022 он)	Хувь
		Багц 1	Сургалтын зардал-4,3 сая	Сургалтын зардал-4,3 сая	100
		Багц 2	Үр дүнгийн урамшуулал-17,9 сая Хоолны үнийн хөнгөлөлт-20,0 сая Нормын хувцас-2,0 сая Нөхөх олговор-400,000 мян.төг Витаминжуулалт-400,000 мян.төг	Үр дүнгийн урамшуулал-17,9 сая Хоолны үнийн хөнгөлөлт-20,0 сая Нормын хувцас-2,0 сая Нөхөх олговор-400,000 мян.төг Витаминжуулалт-400,000 мян.төг	100
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:				
Зорилт 1.Төрийн албан хаагчийн сургалтын хүрээнд					
Зорилт 1.1 Төрийн албан тушаалд тавих тусгай шаардлагын дагуу мэргэшүүлэх багц сургалтад хамруулах;		Төрийн албан хаагчдын богино болон дунд хугацааны сургалт, мэргэшүүлэх дунд хугацааны болон давтан сургалт, мэргэшүүлэх багц сургалтад хамруулах судалгааг тухай бүр гаргаж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлсэн. Тус газрын мэргэжилтнүүдээс мэргэшүүлэх багц сургалтын хүрээнд ахлах түшмэлийн сургалтад газрын дарга, дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад ахлах мэргэжилтэн, анхан шатны сургалтад 2 байгаль хамгаалагч, богино хугацааны зорилтот сургалтад 3 мэргэжилтэн тус тус хамрагдаад байна.			
Зорилт 1.2 Ажлын байран дахь сургалтыг тасралтгүй хөгжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх;		Төрийн албаны зөвлөлөөс гаргасан “Сургалтын бодлогыг хэрэгжүүлэх тухай” зөвлөмжийн дагуу төрийн албан хаагчдын сургалтын судалгааг гаргаж, байгууллагын сургалтын төлөвлөгөөнд тусган шаардлагатай төсвийг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Тус газраас албан хаагчдыг ажлын байран дээр тасралтгүй хөгжүүлэх хүрээнд байгууллагын дотоод сургалтыг жил бүр тогтмол зохион байгуулж хэвшсэн бөгөөд 2022 онд 3 удаа танхимаар, 3 удаа цахимаар зохион байгуулж, сумдын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүд, байгаль хамгаалагчид, Сум дундын Ойн ангийн албан хаагчид, тус газрын мэргэжилтнүүдийг хамрууллаа. Албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг 6,12 дугаар сард зохион байгуулж, сургалтаар байгаль орчны салбарын эрх зүйн орчин, цаашдын чиг хандлага, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг хэрэгжүүлэх, ойн нөөц, усны нөөц, ан амьтны нөөцийн орлого бүрдүүлэлт, төлөвлөлт, зарцуулалт, тайлагналт, ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, БОАЖГ-аас, e-mongolia-д шилжүүлсэн үйлчилгээ, байгаль орчны статистик тайланг хянах, программд шивэх талаар болон ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ			

	<p>албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”, ЗГ-ын 2022 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11.14-ны өдрийн 600 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”, Авлигын талаарх хууль тогтоомжуудыг танилцуулах зэрэг сэдвүүдийн хүрээнд холбогдох албан хаагчид мэдээлэл хийлээ. Байгууллагын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хариуцсан ажилтай холбоотой салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх талаар зорилт, арга хэмжээ тусгаж үр дүнг тооцон хяналт тавьж ажилласан. Монгол бичгийг албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвших бэлтгэлийг хангах хүрээнд Хүмүн бичиг сонинг захиалж, хэвлэмэл хуудсыг АЕГ-аар захиалж эхийг бэлтгүүлэн монгол бичгийн хэрэглээний программыг Архив бичиг хэргийн ажилтны компьютерт суулгаж туршилт хийж байна. Албан хаагчдын монгол бичгийг сэргээх, мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг ЕБ-ын 4-р сургуулийн багш Тунгалагцээлтэй хамтран зохион байгууллаа.</p>
<p>Зорилт 1.3 Гадаад дотоодын их дээд сургууль, сургалтын байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд төрийн албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, дадлагажуулах сургалтад хамруулах;</p>	<p>“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, зорилтот жилийн хүрээнд сургагч багш бэлтгэх цахим сургалт, “БНХАУ-ын цөлжилтийг сааруулах арга туршлага” сэдэвт сургалт, Геоэкологийн хүрээлэнгээс зохион байгуулсан “Мод бут тарих, мод үржүүлгийн газар байгуулах” сэдэвт цахим сургалтад тус газрын 3 мэргэжилтэн, сумдын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүд, байгаль хамгаалагчдыг хамрууллаа.</p> <p>Тус газрын мэргэжилтнүүдээс 2022 онд хариуцсан ажлын чиглэлээр 25, бакалаврын хөтөлбөрт 1, магистрын хөтөлбөрт 1, докторантурт 1 мэргэжилтэн тус тус хамрагдаж суралцах хугацаанд нь цалинтай чөлөө олгож сурах нөхцлөөр хангасан.</p>
<p>Зорилт 1.4 Төрийн албан хаагчийн зөөлөн үр чадварыг хөгжүүлэх;</p>	<p>Төрийн албан хаагчийн манлайлал, харилцаа, хандлага, ёс зүй, цагийн менежмент зэрэг хувь хүний үр чадварыг эзэмшлүүлэх зорилгоор Удирдлагын академиас зохион байгуулсан богино хэмжээний зорилтот сургалт болон Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 7х4х10 арга зүйн цуврал сургалтуудад тогтмол хамруулж, төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл үр дүнг үнэлэхдээ хандлага, ёс зүй, үр чадварын үнэлгээг хамт олноор үнэлүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хангалттай сайн биелүүлсэн албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгох асуудлыг төсвийн боломжид тулгуурлан шийдвэрлэсэн.</p>
<p>Зорилт 2. Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хүрээнд</p>	
<p>Зорилт 2.1 Ажлын байрны ажиллах орчин, нөхцлийг сайжруулах;</p>	<p>Тус газраас 2021 онд мэргэжилтнүүдийн ажлын байрны нөхцлийг сайжруулах зорилгоор 3 өрөөнд засвар хийж, шалыг сольж, хананд акустка хавтан нааж тохижуулан, 1 мэргэжилтний компьютерийг шинэчиллээ. Сумдын 5 байгаль хамгаалагч, 4 мэргэжилтэнд өвлийн хувцас, өвлийн малгай 9 ш хийлгэхээр цэргийн хувцасны “Бөртэ” ХХК-тай гэрээ байгуулж, дээрх арга хэмжээнд шаардагдах зардлыг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас шийдвэрлэж нийт 10,0 сая төгрөг зарцуулсан. 2022 онд төсвийн боломжид тулгуурлан 7 мэргэжилтэн 3 байгаль хамгаалагчийг хөдөө гадаа явахад зориулж 10ш нэхий дотортой өвлийн гутлаар хангаж 2,0 сая төгрөг зарцуулсан. Ажилтнуудын үдийн амралт болон илүү цагаар ажиллах үед нь богино хугацаанд алжаал тайлах зорилгоор ус буцалгагч, цай, кофегоор хангаж ажилласан.</p>

<p>Зорилт 2.2 Ажиллах эрч хүч, урам зоригийг нэмэгдүүлэх;</p>			<p>-Албан хаагчдад ажиллах эрч хүч, урам зоригийг нэмэгдүүлэх хүрээнд 2022 онд байгаль орчны салбарт үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчдыг салбарын шагналаар шагнуулахаар тодорхойлж, Байгаль орчны тэргүүний ажилтан цол тэмдэгээр 3 хүн, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны жуух бичгээр 4, БОАЖГ-ын даргын жуух бичгээр 3, өргөмжлөлөөр 2 албан хаагчийг тус тус шагнаж урамшуулсан.</p> <p>-Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр үнэлж дүгнэн төсвийн боломжид тулгуурлан үр дүнгийн урамшуулал олгосон.</p> <p>-2022 онд төрийн жинхэнэ албан хаагчдаас зэрэг дэв ахиулах болон шинээр олгох саналыг холбогдох материалын хамт Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд уламжилж, аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн б/10 дугаар захирамжаар 3 мэргэжилтэн, 3 байгаль хамгаалагчийн зэрэг дэвийг ахиулж, 2 байгаль хамгаалагчид шинээр зэрэг дэв олгосон. Байгууллагын дэргэдэх Гэр бүлийн зөвлөл, Спорт хамтлаг болон хамт олны сонирхол, хөгжилд тулгуурласан үйл ажиллагаанд зохих дэмжлэг үзүүлж ажилласан.</p>								
<p>Зорилт 2.3 Нийгмийн баталгаа, амьдрах орчин, нөхцлийг сайжруулах;</p>			<p>Байгууллагын албан хаагчдын орон байрны судалгааг гаргаж 2022 онд ердийн галлагаатай хувийн байшинд амьдардаг 3 мэргэжилтэнд нөхөх олговор олгосон.</p> <p>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/451 дүгээр тушаалаар “Байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр” батлагдаж, уг хөтөлбөрийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас байгаль хамгаалагчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж тус газрын харъяа ажиллаж байгаа сумдын байгаль хамгаалагчдыг уг даатгалд хамруулсан. Албан хаагчдад сар бүр олгох хоолны үнийн хөнгөлөлтийг үзүүлж, бусад тусламж, нөхөх төлбөрийг дотоод журмын дагуу өөрсдийн дотоод нөөц боломжид тулгуурлан шийдвэрлэж байна.</p>								
<p>Зорилт 2.4 Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх;</p>			<p>Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээ, оношлогоонд хамрцуулах ажлыг зохион байгуулж, дархлааг дэмжих зорилгоор витаминжуулсан.</p>								
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)		Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны дагуу холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх.								
8.	Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ										
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ,	Биелэлт дундаж	Нийт зорилт	Зорилт 1.1	Зорилт 1.2	Зорилт 1.3	Зорилт 1.4	Зорилт 2.1	Зорилт 2.2	Зорилт 2.3	Зорилт 2.4

		96,2	2	70	100	100	100	100	100	100	100
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ									
		96,2									

БИЕЛЭЛТИЙГ ХЯНАСАН:
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА

Г.БАЯСГАЛАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД
АЖИЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЗОЛЗАЯА